

СУРГАЛТЫН АЛБАНЫ МЕНЕЖЕР



Ц.ОДОНЧИМЭГ
2024.02.27

“ХАМТЫН МАНЛАЙЛАЛ” АЯНЫ ХҮРЭЭНД ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН ЦАХИМ КОНТЕНТ БҮТЭЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

Зорилго: Багш нарын хамтын ажиллагааг эрчимжүүлэн дэмжих замаар багш нэг бүр ажлын байрандаа мэргэжлийн тасралтгүй хөгжлөө ханган, бие биенээсээ суралцаж, хамтран хөгжих боломжийг олгоход чиглэнэ.

Хамрах хүрээ: Уг аянд оролцож буй 5 баг

Хугацаа: 2024.02.26-03.08 хүртэл контентоо бүтээгээд, дараагийн 2 долоо хоногт туршиж сайжруулаад, контентын танилцуулга, үр дүнгийн тайлантай хамт 02.25-29-нд СА-нд ирүүлнэ.

Ээлжит хичээлийн цахим контент

Тухайн ээлжит хичээлийн агуулгыг суралцагчдад ойлгомжтой байдлаар дүрслэн үзүүлж, тайлбарлахад чиглэсэн, логик уялдаа холбоо бүхий цахим хэрэглэгдэхүүний багцыг ойлгоно.

Тавигдах шаардлага:

1. Сургалтын хөтөлбөр, агуулга арга зүйд нийцсэн, танин мэдэхүйн үйлийг /сэргээн санах, ойлгох, хэрэглэх, задлан шинжлэх, үнэлэх, бүтээх чадвар/ дэмжсэн байхаар боловсруулах
2. Тухайн хичээлийн нэг цагийн агуулгыг интеграцчилан 15-20 минутад багтаасан байх
3. Суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон, сонирхол сэдэл төрүүлэхүйц агуулгыг зурагт үзүүлэн, танилцуулга, аудио, видео, интерактив хэлбэрээр дүрслэн үзүүлсэн байх
4. Дуу, дүрс, зураглал чанарын шаардлага хангасан, нягтаршил сайтай байх
5. Бие даан ажиллах дасгал даалгавар, нэмэлт материалыг агуулсан байх
6. Ээлжит хичээлийн цахим контент нь эхлэл, үндсэн, бататгал, нэмэлт /баяжуулалт/ гэсэн 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэх
7. Суралцагчдын идэвх оролцоо, суралцахуйг дэмжсэн, төлөвшил хандлагад нөлөөлөхүйц байх
8. Баг тус бүр 2 ээлжит хичээлийн цахим контент бэлтгэх

СУРГАЛТЫН АЛБА